



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	М.Дүүрэнжаргал
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.25 № 14/287

танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА У.БАЯРБИЛЭГ ТАНАА

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр байсан.

Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

1. Шалгагдагч байгууллага нь тайлант оны эцэст арилжааны банкин дахь түр харилцах дансанд 41.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг бэлэн мөнгөөр гарган авсан бөгөөд буцаан арилжааны банкинд тушаагаагүй. Мөн санхүүгийн тайланг бэлтгэхдээ бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийгээгүй, үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.4-т "мөнгөн хөрөнгө, ... бараа, сав, боодлыг сар бүр /сар бүрийн 1-нээр/ тооллогыг явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6-т "...энэхүү орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд байршуулна" гэж заасныг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Сумын Өрхийн эрүүл мэндийн төвөөс авах авлага 23.0 сая төгрөгийг арилжааны банкин дахь жижиг мөнгөн сангийн дансаар авч бэлнээр гарган авсан. Мөн ахмадын хорооны өрөөг тохижуулах тоног төхөөрөмжийн зардалд орон нутгийн нөөц хөрөнгөөс 6.0 сая төгрөгийг шилжүүлэн бэлнээр гарган авсан бөгөөд тоног төхөөрөмжийг бүрэн хүлээж аваагүй гэх шалтгаанаар мөнгийг шилжүүлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6-т "...энэхүү орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд байршуулна" гэж заасныг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Чандмань Бадрал ӨНОХХК татан буугдсантай холбоотой 210.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн орлогыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Иргэн, аж ахуйн нэгжээс 113.7 сая төгрөгийг бэлэн мөнгө, 77.2 сая төгрөгийн бараа материалыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шууд хүлээн авч, зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1 дэх заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Боловсруулсан
Хянасан:
010000105

5. Нэг цонхны үйлчилгээ багийн хөгжлийн төвийн хөрөнгө оруулалтын ажлын 100.0 сая төгрөгийг сумын Онцгой комиссын үндсэн үйл ажиллагаанд зарцуулснаар өглөг үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчиж, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын захиалагчийн хяналтын зардал болох нийт 152.1 сая төгрөгийн үлдэгдлээс сумын Онцгой комиссын хоол, хүнсний зардалд 111.7 сая төгрөгийг зарцуулсан гэх боловч анхан шатны баримтын бүрдэл дутуу учир бодит гарсан зардлыг баталгаажуулах хангалттай, зохистой нотолгоо бүрдүүлэх боломжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөөлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар 868.1 сая төгрөгийн 13 залруулагдах боломжгүй алдаа зөрчил байгаа нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг өргөн хамарсан ба хангалттай, зохистой нотолгоо бүрдүүлэх боломжгүй байна.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	506.9	515.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,164.8	2,914.4
	Нийт хөрөнгийн дүн	2,671.7	3,429.9
	Нийт өр төлбөрийн дүн	40.7	118.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,631.0	3,311.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,671.7	3,429.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,939.2	3,913.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,990.0	3,191.3
	Үйл ажиллагааны үр дүн	(50.8)	721.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(41.1)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(50.8)	680.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	(32.3)	680.6
	Эцсийн үлдэгдэл	2,630.9	3,311.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,845.8	2,532.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,845.8	2,518.8
	Үйл ажиллагааны ЦМГ	-	13.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	66.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	(53.2)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	846.2	1,077.7
	Урсгал зардал	846.2	1,141.3
	Хөрөнгийн зардал	-	(63.6)
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	846.2	1,066.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	846.2	1,066.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм, төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ. Засаг даргын дэргэдэх тасаг, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ. Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сумын Онцгой комиссын орлого болон зарлагын нийт гүйлгээ тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин зарцуулагддаг байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,457.3 сая төгрөгийн 65 орлогын гүйлгээ, 1,457.3 сая төгрөгийн 86 зарлагын гүйлгээ, 1,457.3 сая төгрөгийн 86 худалдан авалтын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 385.7 сая төгрөгийн 56 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш 1,282.9 сая төгрөгийн 82 худалдан авалтын гүйлгээг, 120.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Арилжааны банкин дахь түр харилцах дансны гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээ, сумын Онцгой комиссын зардалд дүн шинжилгээ хийх болон өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг давтан гаргасан эсэхийг шаардлагатай.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,081.8 сая төгрөгийн 16 алдаа зөрчил илэрснээс, 213.7 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 6.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 829.3 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 32.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд хандиваар хүлээн авсан 113.7 сая төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод тайлагнасан байна.
2. 2020 оны аудитлагдсан тайлангаас санхүүгийн байдлын тайлангийн банкинд байгаа мөнгөний үлдэгдэл 18.7 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн нэгтгэлийн үед залруулсан байна. Мөнгөн гүйлгээний тайланд нэг удаагийн тэтгэмж, урамшуулал болон төвлөрүүлэх шилжүүлгийг зөрүүтэй дүнгээр тайлагнасан байна. Мөн өмчийн өөрчлөлтийн тайланд үлдэгдэл 18.7 сая төгрөгийн зөрүү үүссэн.
3. Аймгийн хөрөнгө оруулалтын 100 сая төгрөгийн 58.0 сая төгрөгийн сумын хөрөнгө оруулалтын сангаас шилжүүлж, 42.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгө

оруулалтын ажлын 100.0 сая төгрөгийг СОК-ийн үйл ажиллагаанд зарцуулсан байгаа бөгөөд өглөг, авлага тусгаагүй байна.

Зөвлөмж

1. Байгууллагын үйл ажиллагаанд 614 ширхэг 141.2 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.
2. Шалгагдагч байгууллага нь НБББББ-ийг боловсруулаагүй.
3. Мөнгөн кассын журамд зааснаас бусад зардлын 32.6 сая төгрөгийн бэлэн мөнгийг түр дансаар дамжуулан гаргасан байна.

Албан шаардлага:

1. Аймгийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хүлээн авсан бөгөөд аймгийн хөрөнгө оруулалтын 117.5 сая төгрөгийг, НҮБ-ийн Хүнс, ХАА-ын газрын ажлын 11.2 сая төгрөгийг, Чандмань бадрал ХХК-аас орж ирсэн санхүүжилтийн төслөөс 23.3 сая төгрөгийг СОК-ын үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 заалтыг зөрчиж, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн тооллогын хийсэн гэх боловч хангалттай, зохистой нотолгоо байхгүй. Бэлэн мөнгөний тооллогыг хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.4 заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Цагийн тооцоо байхгүйн улмаас СОК-д зарцуулсан хоол хүнс болон шатахууны зардлын бодит гүйцэтгэлийг тулгах боломжгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 болон 13.7 заалтыг зөрчиж, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Чандмань Бадрал ХХК татан буугдсантай холбоотой 210.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн харилцахын дансанд хүлээн авсан нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Иргэн, аж ахуйн нэгжээс 113.7 сая төгрөгийг бэлэн мөнгөөр, 77.2 сая төгрөгийн бараа материалыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шууд хүлээн авч, зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1 заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
6. Шалгагдагч байгууллага нь Борхойн наран ЭМТ-өөс багцын үнэ болох 23.0 сая төгрөгийг төрийн сангийн гүйлгээ хаагдсан гэх шалтгаанаар түр дансаар дамжуулан бэлнээр гарган авсан бөгөөд буцаан байршуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6 дахь заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
7. Арилжааны банкин дахь түр харилцах дансны хуулгыг үзэхэд 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 41.4 сая төгрөгийг бэлэн мөнгөний нярав бэлнээр хүлээн авч, сейфэнд байршуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6 дахь заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
8. Авлага, өглөгийн журналыг шүүж үзэхэд аймгийн хөрөнгө оруулалтын ажлын төсвийг сумын Онцгой комиссын үндсэн үйл ажиллагаанд зарцуулснаар өглөг үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг зөрчиж, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн акт:

1. 2016-2017 оны албан тушаалын байрны халаалтын зардалд 0.1 сая төгрөг төлөгдөөгүй өр үүссэнийг үндсэн үйл ажиллагааны тогтмол зардлаас төлсөн.
2. Арилжааны банкны орлого, зарлагын хуулгыг шүүж үзэхэд, ахмадын хорооны өрөөг тохижуулах тоног төхөөрөмжийн зардалд орон нутгийн нөөц хөрөнгөөс 6.0 сая төгрөгийг шилжүүлэн бэлнээр гарган авсан бөгөөд тоног төхөөрөмжийг бүрэн хүлээж аваагүй гэх шалтгаанаар мөнгийг шилжүүлээгүй байна.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1						1
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	16	871.8	3	213.7	2	6.2	8	619.3	3	32.6
НИЙТ		16	871.8	3	213.7	2	6.2	8	619.3	3	32.6

/сая төгрөгөөр/